



“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь “Тэнгэрлиг Медиа Групп” ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрх, ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг хэн хэзээ хэрхэн гаргах, хурлаар хэлэлцэх асуудлыг хэн хариуцан хэдийд бэлэн болгох, хурлын товын талаар болон хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий хяналтын байгууллагад хэрхэн мэдээлэх, хурлыг хэрхэн зохион байгуулж, удирдан явуулах, санал өгөх, шийдвэр гаргах, түүнийг хэрхэн албажуулах, хурлын материалыг хэрхэн шалгаж, баримтжуулан хадгалах болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД БЭЛТГЭХ

НЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ

1.1. Ээлжит хурал:

- 1.1.1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59.4-т зааснаар санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулах үүрэгтэй.
- 1.1.2. Энэхүү Журмын 1.1-д заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.
- 1.1.3. ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.
- 1.1.4. Энэхүү Журмын 1.1.3-д заасан ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ТУЗ нь ажлын 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулаагүй бол хурал зарлан хуралдуулах эрх бүхий бусад этгээд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж болно.

1.2. Ээлжит бус хурал:

- 1.2.1. Компанийн ээлжит бус хурлыг дараах эрх бүхий этгээд зарлан хуралдуулна.
 - 1.2.1.1. Компанийн ТУЗ эсхүл
 - 1.2.1.2. ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан,
 - 1.2.1.3. Компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал шаардлага гаргасан (цаашид “хурал зарлагч этгээд” гэх)
- 1.2.2. Компанийн тухай хуулийн 61.1-р зүйлд заасан дараах үндэслэлээр болон Компанийн дүрэмд заасан бусад үндэслэлээр хэдийд ч зарлан хуралдуулж болно.
 - 1.2.2.1. ТУЗ-ийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
 - 1.2.2.2. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн,
 - 1.2.2.3. саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
 - 1.2.2.4. Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
 - 1.2.2.5. Компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
- 1.2.3. ТУЗ шийдвэр гаргасан;
- 1.2.4. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
- 1.2.5. Компанийн дүрэмд заасан бусад тохиолдол



Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2021 оны 08 сарын 06-ны өдрийн
21/24 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт

- 1.3. Энэхүү Журмын 1.2.1.2, 1.2.1.3-г заасан этгээд санал, шаардлагыг бичгээр гаргах бөгөөд түүнд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, хурлаас гаргах шийдвэрийн төсөл, өөрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог заана.
- 1.4. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана.
- 1.5. ТУЗ дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрийн үндэслэлийн талаар санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчид нэн даруй мэдэгдэнэ:
 - 1.5.1. хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчийн саналын эрх нь нийт саналын эрхийн 10 хувьд хүрээгүй;
 - 1.5.2. хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэхээр санал болгож байгаа асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй.
- 1.6. Энэ хуулийн санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахаас татгалзсан ТУЗ-ийн шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргаж болно.
- 1.7. Энэ Журмын 1.4-т заасан хугацаанд ТУЗ шийдвэр гаргаагүй тохиолдолд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч, эсхүл ТУЗ-ийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.
- 1.8. Энэ Журмын 1.7-д заасан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал зөвшөөрвөл хурлыг зарлах, хуралдуулахтай холбогдсон зардлыг Компани хариуцаж болно.
- 1.9. ТУЗ нь энэ Журмын 1.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.
- 1.10. Энэ журмын 1.9-д заасан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг Компани хариуцна.
- 1.11. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.
- 1.12. **Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:**
 - 1.12.1. хурал хуралдуулах арга хэлбэр, газар, өдөр, цаг;
 - 1.12.2. хурлын хэлэлцэх асуудал;
 - 1.12.3. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
 - 1.12.4. хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
 - 1.12.5. хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
 - 1.12.6. саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;
 - 1.12.7. саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
 - 1.12.8. хурлын дарга;
 - 1.12.9. тооллогын комиссын дарга, гишүүд.

ХОЁР. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ХЭЛБЭР, ХУРЛЫН ТОВ

- 2.1. **Хурал хуралдуулах зарчим**
 - 2.1.1. Компанийн төв захиргаа оршин байгаа газраас өөр газарт хуралдуулахаар тогтоосон бол хувьцаа эзэмшигчдийн олонх нь оршин сууж байгаа хувьцаа эзэмшигчдэд хамгийн тохиромжтой байх байршил, цаг, хэлбэрийг сонгоно.
 - 2.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа эзэмшигчид ажлаас хөндийрөлгүй оролцох боломжоор хангахын тулд долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулах нь зүйтэй.
 - 2.1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг өглөөний 10 цагаас эртгүй ба орой 18 цагаас хойш бус байхаар товлон.
 - 2.1.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш хурлын тов, хурал хуралдах газарт өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 2.2. **Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах хэлбэр**



- 2.2.1. Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр эсхүл Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцох байдлаар;
- 2.2.2. Эчнээ санал хураалтаар;
- 2.2.3. Телеконференц ;
- 2.2.4. Видео конференц;
- 2.2.5. Компанийн дүрэмд заасан бусад хэлбэрээр;

ГУРАВ.ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ ОРУУЛАХ

3.1. Ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах:

- 3.1.1. Ээлжит хурлаар Компанийн жилийн үйл ажиллагааны¹ болон санхүүгийн тайлангийн² талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдээс хувьцаа эзэмшигчдийн хурал дээр асуулт тавьж, хариулт авах хугацааг заавал хэлэлцэнэ.
 - 3.1.2. Хурал зарлагч этгээд компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчдэд санхүүгийн жил дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх, санал ирүүлэх тухай мэдэгдлийг бичгээр хүргэнэ.
 - 3.1.3. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас 60 хоногийн дотор төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагад гаргаж болно.
- 3.2. Ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах:
 - 3.2.1. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс ажлын 2 хоногийн дотор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах эрхтэй.
 - 3.3. Гүйцэтгэх удирдлага нь хэлэлцэх асуудалд санал оруулах саналыг төлөөлөн удирдах зөвлөлд санал ирсэн өдөрт багтаан хүргүүлнэ.
 - 3.4. Хувьцаа эзэмшигч хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулахдаа саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд гаргаж байгаа санал, түүний үндэслэл, санал оруулж байгаа хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоог тусгана.
 - 3.5. Хувьцаа эзэмшигч ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлбэл нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр /хэрэв компанийн хувьцаа эзэмшигч бол түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо/, нэр дэвшүүлж байгаа хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоог тусгасан мэдэгдлийг бичгээр гаргах бөгөөд уг мэдэгдэлд нэр дэвшүүлж байгаа үндэслэлээ зааж болно.

¹ Үйл ажиллагааны тайлан дараах мэдээллийг агуулсан байна.

- Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл
- Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь
- Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсэж болох эрсдэлийн тухай мэдээлэл;
- Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;
- Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан;
- Нийгмийн хариуцлагын тайлан;

² Санхүүгийн тайлан дараах мэдээллийг агуулсан байна.

- Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
- Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар, тодруулга, дүгнэлт;
- Тайлант хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зорчилтэй хэлцэл, тэдгээрийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт
- Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний харьцаа;
- Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл



Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2021 оны 08 сарын 06-ны өдрийн
21/24 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт

- 3.6. Компанийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх хүний тоо нь сонгогдох нийт хүний тооноос хоёр дахин их байна.
- 3.7. Хувьцаа эзэмшигчийн дэвшүүлэх санал нь тухайн саналыг хурлын хэлэлцэх асуудалд шууд тусгахуйцаар найруулан бичигдсэн байна. Мөн гаргах шийдвэрийн төслийг агуулсан байж болно.
- 3.8. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд дэвшүүлэх саналыг дараах хэлбэрээр хүргүүлж болно:
 - 3.8.1. Баталгаат шуудангаар дараах хаягаар явуулах: _____-ны анхааралд _____ (тухайн саналыг хүлээн авах эрх бүхий хүний нэр, албан тушаалыг бичнэ);
 - 3.8.2. Биечлэн хүргэх, саналыг хүлээн авсан хүний гарын үсэг бүхий нотолгоог авна. (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсвэл компанид хаягласан бичиг баримтыг хүлээн авах эрх бүхий хүн)
- 3.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах болон компанийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэхтэй холбогдсон саналыг хүргүүлэхдээ хувьцаа эзэмшигч нь гарын үсгээ зурна.
- 3.10. Хэрэв тухайн саналд хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан бол хуулийн заалтын дагуу хийгдсэн итгэмжлэлийг (эсвэл итгэмжлэлийн баталгаажуулсан хувь) хавсаргана.
- 3.11. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал болон нэр дэвшүүлэх саналыг бичгээр үйлдэх ба дараах асуудлыг тусгана:
 - 3.11.1. Санал дэвшүүлж байгаа хувьцаа эзэмшигчийн нэр;
 - 3.11.2. Эзэмшиж байгаа хувьцааны тоо ба төрөл;
 - 3.11.3. Дэвшүүлж байгаа саналын тухай болон тухайн саналыг дэвшүүлэх болсон шалтгаан;
- 3.12. Компанийн удирдлагад нэр дэвшүүлэх тохиолдолд дараах мэдээллийг оруулна:
 - 3.12.1. Нэр дэвшигдэж байгаа хүний овог, нэр;
 - 3.12.2. Нэр дэвшигдэж байгаа хүн нь компанийн хувьцаа эзэмшигч бол түүний эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл;
 - 3.12.3. Нэр дэвшүүлэх болсон шалтгаан;
 - 3.12.4. Чухам ямар албан тушаалд нэр дэвшүүлж байгаа;
 - 3.12.5. Тухайн нэр дэвшигчтэй холбогдсон бусад мэдээллийн материал;
 - 3.12.6. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол нэр дэвшүүлж байгаа этгээд нь хуульд заасан хараат бус гишүүний шаардлагыг хангаж байгаа талаар саналдаа тусгах;
- 3.13. ТУЗ тухайн саналыг хянаж, саналыг хүлээн авснаас хойш ажлын арван таван өдөрт багтаан саналыг хүлээн авч байгаа эсвэл татгалзаж байгаа талаар шийдвэр гаргана. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын талаар гаргасан санал, шийдвэрийн төслийн томъёоллыг өөрчлөхгүй.
- 3.14. ТУЗ тухайн саналыг хэлэлцэх асуудалд оруулах, эсвэл нэр дэвшүүлж байгаа хүнийг компанийн удирдлагад нэр дэвшигчдийн жагсаалтад оруулах эсэх талаарх ТУЗ-ын шийдвэрийг тухайн саналыг дэвшүүлсэн хувьцаа эзэмшигчид шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдөрт багтаан, татгалзсан бол шалтгааны хамт мэдэгдэнэ.
- 3.15. **ТУЗ дараах нөхцөлөөс бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хэлэлцэх асуудалд оруулах санал болон нэр дэвшүүлж байгаа хүний нэр дэвшигчдийн жагсаалтад оруулна:**
 - 3.15.1. Санхүүгийн жил дууссанаас 60 хоногийн дотор хувьцаа эзэмшигч өөрийн саналыг хүргүүлээгүй бол;
 - 3.15.2. Саналын эрх бүхий 5 буюу түүнээс дээш тооны хувьцааг санал гаргагч нь эзэмшээгүй бол;
 - 3.15.3. Журмын 3.5- 3.12-д заасан шаардлагыг хангаагүй бол;
 - 3.15.4. Хэлэлцэх асуудалд оруулахаар дэвшүүлж байгаа санал нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх мэдлийн хүрээнд хамаарахгүй, эсвэл хуулийн шаардлагыг хангахгүй бол.
- 3.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд оруулах хувьцаа эзэмшигчийн санал дээр нэмж, эсвэл хувьцаа эзэмшигчдээс санал огт ирээгүй, эсвэл компанийн удирдах байгууллагад нэр дэвшүүлж байгаа хүний тоо нийт сонгогдох хүний тоонд хүрэхгүй байгаа



- бол ТУЗ нь өөрийн үзэмжээр хурлаар хэлэлцэх асуудал нэмж санал оруулах эсвэл нэмж нэр дэвшүүлэх эрхтэй болно.
- 3.17. ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь саналыг ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.
 - 3.18. Журмын 3.17-д заасан ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрийн талаар санал гаргагч шүүхэд гомдол гаргаж болно.
 - 3.19. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын онцлогоос хамааран зарим асуудлыг хэлэлцэх журмыг компанийн дүрмээр тусгайлан тогтоож болно.
 - 3.20. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтын бусад гэсэн хэсэг байх шаардлагатай бол энэ нь хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах эрхтэй этгээдийн санал байх ба мөн Компанийн тухай хуулийн 62.1-д заасан асуудал байна.

ДӨРӨВ. ХУРАЛД ОРОЛЦОХ ЭРХТЭЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ ГАРГАХ БҮРТГЭЛИЙН ӨДӨР

- 4.1. Хувьцаат компанийн хувьд бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.
- 4.2. Бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр болон хувьцаа эзэмшигчдийн хурлын зард заана.
- 4.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт нь
 - хувьцаа эзэмшигч бүрийн эцэг /эх/-ийн нэр;
 - өөрийн нэр;
 - оршин суугаа газрын хаяг;
 - түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тооны талаарх мэдээллийг агуулсан байна.
- 4.4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч хуралд оролцоно.
- 4.5. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээдийн шаардсанаар түүнд танилцуулах үүрэгтэй.

ТАВ. ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ

- 5.1. **Хурлын зар хүргэх хугацаа:**
 - 5.1.1. Компани нь хувьцаа эзэмшигчийн тоо, хэмжээнээс хамааруулан хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ.
- 5.2. **Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх арга, хэлбэр:**
 - 5.2.1. Өдөр тутмын сонин;
 - 5.2.2. Орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио эсхүл телевиз;
 - 5.2.3. Арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудас;
 - 5.2.4. Цахим шуудангаар зэрэг харилцаа холбооны бусад хэрэгсэл;
 - 5.2.5. Компанийн дүрэмд заасан бусад хэлбэр, давтамжаар;
- 5.3. **Хурлын зард дараах мэдээллийг заавал тусгана.**
 - 5.3.1. Компанийн оноосон нэр, байршил;
 - 5.3.2. Хурал хийх өдөр, цаг, газар;
 - 5.3.3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
 - 5.3.4. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
 - 5.3.5. Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах журам, газар ажиллах цаг;



Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2021 оны 08 сарын 06-ны өдрийн
21/24 тоот тогтоолын Нэгдүгээр хэсэртэй хамт

- 5.3.6. Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утасны дугаар, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;
- 5.3.7. Компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

- 6.1. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахтай холбоотой шаардлагатай бүхий л мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 6.2. Компани аливаа мэдээллийг Монгол хэлээр хүргэх ба шаардлагатай гэж үзвэл гадаад хэлээр хувьцаа эзэмшигч нарт хүргэж болно.
- 6.3. Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах ажиллагааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга\байхгүй бол хурал зохион байгуулагч\ гүйцэтгэнэ.
- 6.4. Хурал зарлагч этгээд нь хувьцаа эзэмшигчдийн хурлын материал, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичигтэй танилцах, судлах боломжоор хувьцаа эзэмшигчийг хангах үүднээс дараах арга хэмжээг авч ажиллана.
 - 6.4.1. Компанийн вэбсайтад мэдээллийг тогтмол байршуулах;
 - 6.4.2. Хурлын товхимол бэлтгэж тараах;
 - 6.4.3. Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах газарт, ажиллах цаг хуваарийн дагуу хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах;
- 5.3.8. Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утасны дугаар, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарийг тогтмол зарлах;

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОХ ЖУРАМ

- 1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн эрх барих дээд удирдлага байна.
- 1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа эзэмшигчдийг дараах боломжоор хангана.
 - 1.2.1. Компанийн үйл ажиллагааг хянах;
 - 1.2.2. Компанийн үйл ажиллагааны талаар гаргаж буй чухал шийдвэрүүдийг хэлэлцэх, шийдвэр гаргахад оролцох;
 - 1.2.3. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх, удирдлагын талаарх, санхүүгийн болон санхүүгийн бус бүхий мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллүүдийг авах;
 - 1.2.4. Компанийн ногдол ашгийн бодлогыг тодорхойлоход оролцох;
- 1.3. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх үндсэн эрхээ хэрэгжүүлж хэлэлцэж байгаа асуудлаар эсрэг саналтай байгаа бол
 - 1.3.1. өөрийн байр суурь, түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарлаад саналын хуудсаар саналаа өгөх;
 - 1.3.2. Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д заасан асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх;
 - 1.3.3. Компанийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т заасны дагуу Хувьцаат компанийн хуралд оролцоогүй, эсхүл хуралд оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч энэ хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д зааснаар шүүхэд нэхэмжлэл гаргах зэргээр хуульд заасан эрхээ хэрэгжүүлээд явах боломжтой тул
 - Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа оролцоогүй байх;
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлын дундаас хаяж явах нь



Компанийн дүрэмд заасан хурал хүчин төгөлдөрт тооцох, хурлын шийдвэр хүчин төгөлдөрт тооцох хувь хэмжээнд хүрч байвал тухайн хурлыг үргэлжлүүлэхгүй байх эсхүл хойшлогдсон хурлыг зарлан хуралдуулахгүй байх үндэслэл болохгүй.

1.4. Хурлын даргын чиг үүрэг:

1.4.1. Хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалах боломжгүй болсон тохиолдолд энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-д мэдэгдэх ба төлөөлөн удирдах зөвлөл хурлын даргыг хурал болохоос өмнө дахин томилоно.

1.5. Тооллогын комиссын чиг үүрэг

1.5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргасан этгээд хурлын тооллогын комиссыг томилох бөгөөд уг комиссын үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр тогтоож болно.

1.5.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.

1.5.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ:

- хурлын ирц /кворум/-ыг тогтоож, хурлын даргад мэдээлэх;
- тухайн хурлын хэлэлцэх асуудал тус бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох;
- хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх;
- санал өгөх журмыг тайлбарлах;
- санал өгөх журам болон хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
- санал хураалтыг саналын хуудсаар явуулж байгаа тохиолдолд уг саналын хуудсыг тоолж, хүлээн авах;
- санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;
- санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах;
- саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.

1.5.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.

1.5.5. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисст хурал хуралдуулахтай холбогдсон бусад үүргийг хариуцуулж болно.

НАЙМ.ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

8.2. Энэ журмын 8.1-д заасан хувь хүрээгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хурал зарласан этгээд/ товлох бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно.

8.3. Компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.

8.4. Компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол дараах асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.

8.4.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

8.4.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

8.4.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

8.4.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;



Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2021 оны 08 сарын 06-ны өдрийн
21/24 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт

- 8.4.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 8.4.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- 8.5. Энэ журмын 8.2-т заасны дагуу хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээнэ.
- 8.6. Хувьцаат компанийн хувьд энэ журмын 8.2-т заасны дагуу хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.
- 8.7. Энэ журмын 8.3-т заасны дагуу хүчин төгөлдөр бус гэж үзсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцно.
- 8.8. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал нь энэ журмын 8.5-д заасан хугацаанд хуралдаж чадаагүй бол шинээр хурал зарлах бөгөөд ирц /кворум/ -ийг Компанийн тухай хуулийн 69.1-д зааснаар тогтооно.

ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 9.1. Хурлаас гарах шийдвэрийн агуулга хувьцаа эзэмшигчдэд тодорхой ойлгомжтой байх ёстой. Ингэснээр хэлэлцэж буй асуудалд санал өгөх үйл ажиллагаа шуурхай хялбар болох бөгөөд асуудлыг буруу ойлгох, үл ойлголцол гарах түүнээс шалтгаалан буруу шийдвэр гаргах зэргээс сэргийлнэ.
- 9.2. Хувьцаа эзэмшигч саналаа өгөхдөө “зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн үгээр илэрхийлэх ба саналыг ил тод байдлаар эсвэл бичгээр авах гэсэн хэлбэрээр явуулж болно. Саналыг тухайн хувьцаа эзэмшигчийн саналыг тоог тусгасан бөгөөд “зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн үгээр илэрхийлэгдсэн урьдчилан бэлтгэн гаргасан саналын хуудсаар, бичгээр авах нь зүйтэй.
- 9.3. Санал хураалтын үр дүнг санал тоолох комисс нэгтгэн үр дүнг гаргана.
- 9.4. Саналын хуудаст дараах мэдээллийг тусгасан байна:
- 9.4.1. Компанийн нэр, хаяг
- 9.4.2. Хурлын байр, байршил, өдөр, цаг
- 9.4.3. Хурлын хөтөлбөр
- 9.4.4. Хурлын хөтөлбөрт тусгагдсан асуудал бүрээр санал өгөх сонголтод “зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн хариултыг ашиглана.
- 9.5. Хувьцаа эзэмшигч нь “зөвшөөрсөн”, “татгалзсан” аль нэгийг сонгон саналаа өгнө.
- 9.6. Хурлын хөтөлбөрт тусгагдаагүй асуудлаар шийдвэр гаргахдаа батлахгүй байж болно. Иймд хөтөлбөрт тусгагдсан асуудал бүрд хувьцаа эзэмшигчид санал өгөх боломжийг хангах үүднээс хурлын дарга хэлэлцэх шаардлагатай бүх асуудлыг хурлын хөтөлбөрт бүрэн гүйцэд тусгах асуудлыг хариуцаж ажиллана. Хэлэлцэж буй асуудал тус бүрээр санал хураалт явуулна. Хоёр буюу түүнээс олон асуудлыг зэрэгцүүлэн санал хураалтыг явуулахыг хориглоно.
- 9.7. Хурлын шийдвэрийг компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд шуурхай хүргүүлнэ.
- 9.8. Хувьцаа эзэмшигч хуралд биеэр ирж чадахгүй тохиолдолд бичгээр саналаа өгөх ба “зөвшөөрсөн”, “татгалзсан” үгсийн аль нэгийг сонгон илэрхийлж өөрийн гарын үсгийг зурсан байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг хурал хуралдсанаас хойш ажлын 3 хоногт багтаан гаргаж хурлын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулах ба түүнчлэн тэмдэглэл хөтөлсөн хурлын нарийн бичгийн даргын гарын үсэг зурагдсан байна.
- 9.9. Хэрэв хувьцаа эзэмшигч хурал хуралдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор бичгээр хурлын тэмдэглэлтэй танилцах хүсэлт гаргасан тохиолдолд түүнд тэмдэглэлийн хуулбарыг хүргүүлнэ. Хурлаас гарсан шийдвэрийг аливаа төрийн болон бусад байгууллагад бүртгүүлэх шаардлагатай бол энэхүү ажлыг хурлыг зохион байгуулсан комисс ажлын холбогдох журамд заасан хугацаанд багтаан хариуцан гүйцэтгэнэ.
- 9.10. Компанийн дүрэмд хуульд зааснаас дээгүүр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн **олонхын саналаар** хүчин төгөлдөр болно.
- 9.11. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохдоо нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг сонгоно.



- 9.12. Дараах асуудлыг шийдвэрлэх саналын тоог компанийн дүрмээр өндрөөр тогтоогоогүй бол **хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор** шийдвэрлэнэ.
- 9.12.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- 9.12.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- 9.12.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- 9.12.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
- 9.12.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 9.12.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- 9.13. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын онцлогоос хамааран зарим асуудлыг хэлэлцэх журмыг Компанийн дүрмээр тусгайлан тогтоож болно.

